

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-23

---

*1. “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаарх  
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын мэдээлэл сонсох* 3-23

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны  
10 дугаар сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 42 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхбат, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Ч.Ундрэм;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, С.Цэнгүүн.

**Нэг. “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаарх Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

“Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаарх мэдээллийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Галбадрах, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаарх Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцээж дуусав.*

*Нээлттэй хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 00 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
15 цаг 42 минут.

### ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Золжаргал:** Та бүхний өдрийн мэндийг хүргэе. Ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн, жагсаалт, Энхбаярын Батсугар гишүүн байна, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Чинбатын Номин гишүүн ирсэн байна. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн байна. Ингээд нийт гишүүдийн ирц 53.8 хувьтай бүрдсэн байна. Ирц танилцууллаа. Хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт нь “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаар Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Учрал сайд мэдээлэл өгнө. Тэгээд хоёрдугаар асуудал нь бусад асуулт, хаалттай асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу?

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал одоогоор алга байна.

Учрал сайдыг ирсэнд баярлалаа.

**“Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаар Засгийн газрын**

**Хэрэг эрхлэх газрын даргын мэдээллийг сонсьё.**

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны даргын зүгээс “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаарх бас мэдээллийг Байнгын хорооны гишүүдэд өгөөч гэж хүсэлт гаргасны дагуу харилцаа холбооны “Үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийн талаар ерөнхий мэдээллийг өгье.

Бид бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр Засгийн газраас сая шийдвэрлэсний дагуу Аюулгүйн зөвлөл дээр энэ хиймэл дагуулын төслийн яг эцсийн байдлаар танилцуулахад бэлтгэж байгаа. Түүнээсээ өмнө та бүхэнд буюу Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүдэд энэ талаар бас мэдээллийг өгье гэж өнөөдөр та бүхэнтэй уулзаж байна.

Мэдээж энэ харилцаа холбооны Үндэсний хиймэл дагуулын төслийн хэрэгжилтийг хангуулах байгууллага бол төрийн захиргааны төв байгууллага Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, тэгээд Баатархүү сайд бас ирсэн байна.

Миний хувьд бол өнгөрсөн хугацаанд, 2 жилийн хугацаанд энэ салбарын сайдаар ажиллаж байхдаа энэ төслийг бас хэлэлцээрүүдийг нь явуулж байсны хувиар одоо бол яг энэ салбар дундын уялдааг хангуулах, цаашиаад Аюулгүйн зөвлөлөөс шийдвэр гаргаад зээлийн хэлэлцээрийг бас соёрхож батлах гээд процедур явж байгаа. Тийм учраас ажлын хэсгийг ахалж байна. Ажлын хэсгийг ахлаад энэ хиймэл дагуулын төслийн зээлийн хэлэлцээр Их Хурлаар батлагдсаны дараа Цахим хөгжил, харилцаа холбооны сайд бас шууд удирдлагаар хангаад ингээд явна. Одоо бол энэ зөвхөн ажлын хэсгээ гэдгийг би бас та бүхэнд хэлье.

Маш энгийнээр мэдээлэл өгөхөд манай энэ Үндэсний хиймэл дагуул бол өөрөө нөгөө коммуникэйшн сателлайт/communication satellite/ буюу энэ харилцаа холбооны хиймэл дагуул. Тэгэхээр хиймэл дагуулууд бол мэдээж дотроо олон янзын төрөлтэй байгаа.

Тэгэхээр бидний одоо энэ ярьж байгаа хиймэл дагуул бол 36 мянган км-ийн цаана Ай Ти Ю/ITU/ гэж олон улсын цахилгаан холбооны байгууллага бид нарт яг тэр байршилыг өгсөн. Тэр байршилыг бол жил бүр баталгаажуулаад жилийн өмнө Эм Даблю Си/MWC/ буюу Мобайл Ворлд Конгресс/Mobile World Congress/-ын үеэр Ай Ти Ю/ITU/-ээс яг энэ байршлынхаа эрхийг бид нар баталгаажуулсан. Тэгээд “Чингис” гээд байршил бол аль нэг улсын байршил биш. Энэ бол сансар дахь олон улсын цахилгаан холбооны байгууллага буюу НҮБ-ын дэргэдэх энэ байгууллагаас бидэнд олгочихсон ийм байршил гэсэн үг.

Тэгэхээр энэ байршил дээр бол бид нар өөрсдийнхөө хиймэл дагуулыг хөөргөх нь бол энэ манай орны өөрийн дотоодын асуудал. Дээрээс нь энэ НҮБ-ын дэргэдэх Ай Ти Ю/ITU/ буюу энэ олон улсын цахилгаан холбооны байгууллага бол өөрөө ямар нэгэн улсаас гэхээсээ илүү энэ бол НҮБ-ын дэргэдэх байгууллага гэдэг утгаараа улс орнуудад энэ байршилуудыг нь ингэж олгодог.

Тэгээд бид энэ байршилуудыг их олон жил хадгалсан. Хамгийн сүүлд бол яг энэ “Чингис” гэдэг байршилаа тодорхой болгоод энэ бол манай оронд өгөгдсөн ийм байршил байгаа гэдгийг бас бид бас ойлгох ёстой байх гэж бодож байна.

Ер нь бол одоо Баатархүү сайд ч тэр, би ч тэр энэ Харилцаа холбооны сайдаар ажиллаж байхад нэг зүйл их тулгардаг. Энэ юу юм бэ гэхээр ерөөсөө л Их Хурлын гишүүд бүгдээрээ л шилэн кабелиар интернэт оруулж өгөөч, манай багт дэд бүтэц байгуулаач, энд үүрэн холбооны сүлжээ огт байхгүй байна л

гэдэг. Тэгээд бид өнгөрсөн хугацаанд бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг байгуулсан. Үүргийн сангийн санхүүжилтээр бол олон жил бид нар энэ дэд бүтцийг байгуулаад үүрэн холбооны станцуудыг байгуулсан. Тэгээд 330 сумаас бараг л энэ чинь 5 сумаас бусдад нь бүтэн ингээд шилэн кабелийн интернэт орчихсон байгаа. 21 аймаг дээр орчихсон байгаа. Ингээд цаашилаад багууд руу орох ажлууд ч гэсэн хийгдчихсэн.

Өнгөрсөн жил яг ийм Их Хурлын гишүүд хүсэлт тавиад байсан. Тэгээд энэ утгаараа бол 20 тэрбумын санхүүжилт тавиад 10 тэрбумаар нь нэг хэдэн багийг шилэн кабелиар оруулъя гээд бид нар үзсэн. Хэд хэдэн удаа ингээд тендер зарласан. Тэгээд тендерт манай энэ оператор компаниуд энэ тэр бол орж ирэхээ больсон.

Яагаад гэхээр энэ чинь 100, 200 хүнтэй баг дээр дэд бүтэц байгуулаад, антен босгоод, интернэт өгөөд, тэнд 2, 3 хүн ажиллаад, тэнд байгаа тэр дэд бүтцийг нь авч явах 1, 2 давхар байшинг манаад, цалин цавууг нь тавиад явна гэдэг бол маш их зардалтай. Тэгэхээр ийм өндөр зардалтай дээр хэдэн төгрөгөөр ч зарлаад хуучин шиг тэр баг руу сүлжээ орно гэж байхгүй болчхож байгаа юм. Үүнээс болоод өнөөдөр аюулгүй байдлын асуудал яригдаж байна, одоо гэмт хэрэг, зөрчлийн асуудал яригдаж байна, ган, зуд болоход малчид ингээд олддоггүй, хүний амь настай холбоотой асуудлууд яригдаж байна. Тэгээд ийм олон асуудал үүсээд байгаа.

Тэгэхээр үүрэн холбооны сүлжээ гэдэг бол тог, цахилгаантай адилхан асар чухал зүйл энгийнээр бол. Тэгээд хоёр хөршөөсөө бид нар шилэн кабелиар интернэт авдаг. Яг үнэндээ хоёр их гүрний дунд оршиж байгаа энэ улс яг ийм холбоо хамааралтайгаар интернэтийг аваад байх юм бол бусдаас хамааралтай л байгаад байна. Тэгэхээр бид нар далайд гарцгүй ч гэсэн сансарт гарцтай байх, үндэсний аюулгүй байдалтай

холбоотойгоор янз бүрийн асуудал үүсэхэд ямар ч үед сүлжээтэй, холбоотой, харилцаатай байх нь бол бид нарын нэгдүгээр том асуудал учраас одоо бол энэ Үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлбэ, манай улс нэг хиймэл дагуултай болъё гэж аль социализмын үеэс авхуулаад л үе үеийн энэ холбоочид, ахмадууд, дээрээс нь энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр олон жил яригдсан юм билээ. Тэгээд маш их хичээсэн. Тэгээд Ерөнхийлөгч Баттулгын үед бол Энэтхэгтэй хиймэл дагуулын төслийг явуулъя гээд гэрээ зураад ингээд явж байсан. Тэгэхэд тэр технологи нь өөрөө аналог технологи байсан.

Тийм учраас тоон технологийн дэвшилтэт технологийн хиймэл дагуулыг явуулъя гээд нөгөө энд Францын төрийн айлчлал, Францын Ерөнхийлөгчийн Монголд төрийн айлчлал болж байсан үеэр Ерөнхийлөгч ингээд санал тавиад, тэгээд энэ урагшаа хөдөлсөн юм. Тэгэхээр энэ бол өөрөө нөгөө үндэсний аюулгүй байдлын асуудал шүү гэдгийг бас эрхэм гишүүд та бүхнийг бас ойлгоосой гэж бодож байна.

Тэгээд бид нар өнгөрсөн хугацаанд бол та бүхний харж байгаагаар ер нь нэг хүн амьдрах бололцоотой газар нутгийнхаа 23 хувьд л шилэн кабелийг хүргэсэн юм байна. Нийт газар нутгийн зөвхөн 60 хувийг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулахад бараг 28278 бааз, станц байгуулах 11 их наяд төгрөг хэрэгтэй байх. Жил бүр ашиглалтын зардалд 1.7-г төлнө гээд ингээд үзэхээр нийт малчин өрхөд интернэтийг хүргэе гэвэл бид нарт яг 29 их наяд төгрөг хэрэгтэй. 29 их наяд. Тэгэхдээ энэ малчин өрхүүд. Тэрнээс биш багуудаас багуудын хооронд явж байхад нөгөө утасны сүлжээ тасардаг энэ тэр хэвээрээ л байна.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол 1639 багт 292 тэрбум төгрөг зарцуулсан гээд ингээд энэ тоон үзүүлэлтүүдийг харахаар бол зайлшгүй бид нар цаашидаа

хүн л амьдарч байгаа бол интернэттэй болох ёстой, хүн амьдарч байгаа бол олон сувгийг дамжуулах телевиз үзэх ёстой, хүн амьдарч байгаа бол утас, харилцаа холбоотой л байх ёстой шүү дээ.

Одоо хөдөө орон нутагт уулзалт хийхээр малчид бол манай өвөлжөөн дээр интернэт оруулаач гэж бараг хүсдэг л болчихоод байна л даа. Тэгээд энэ хэрэгцээг бид зөв бас мэдрэх хэрэгтэй. Энэ хүмүүс ч гэсэн интернэттэй холбогдмоор байна. Энэ хүмүүс ч гэсэн утас шөрмөсөөр яримаар байна.

Гэтэл энийг шийдвэрлэе гэхээр өнөөдрийн арга барилаараа ингээд явбал энийг хийх хувийн хэвшил ч олдохоо больсон. Тэгээд энэ ажлыг урагшилуулахад энэ санхүүжилтээ ч бид нар дийлэхээ больсон. Шилэн кабелиар орууллаа орууллаа гээд бид нар хоёр хөршөөсөө хамааралтай хэвээрээ л байна. Энэ ерөөсөө хамааралгүй болно гэсэн үг огт биш. Тийм учраас энэ дээр бол энгийнээр ярихад бол бас ийм байгаа.

Тийм учраас сансрын холбооны хиймэл дагуулын цаашидын хэрэглээ ингээд би зардлын тооцооллыг бол энэ ТЭЗҮ дээр тодорхой харуулж байгаа. Монгол Улсын сансрын холбооны хиймэл дагуулын хэрэглээ ирэх 20 жилд 2.5 дахин нэмэгдэх тооцоолол гарсан, ийм ТЭЗҮ батлагдсан.

Тэгээд энэ ТЭЗҮ бол Япончууд анх хийгээд бид нар ТЭЗҮ дээрээ санхүүгийн тооцооллыг шинэчлээд, сая Сансрын зөвлөл дээр ТЭЗҮ-г танилцуулаад батлуулж байгаа. Энэ бол сая бидний хийсэн ТЭЗҮ ч биш энэ бол анх удаа бас ярьж байгаа энэ төсөл ч биш юм байна лээ. Өнгөрсөн хугацаанд яригдчихсан. Тэгээд энд манай Анар гишүүн ингээд мэргэжлийн хүмүүс байгаа. Тэгэхээр хиймэл дагуулын орбитыг бол ингээд Лео, Мео, Гео гээд ингээд ангилдаг юм байна лээ. Гео орбитод бол ийм 36 км-ийн цаана хөөрнө гэж ингэж тооцож байгаа. Энэ бол огт энэ манайд

гадаргуугаас 36 мянган км-ийн цаана энэ хиймэл дагуул хөөрнө гэсэн үг. Үүгээрээ бол мэдээж ялгаатай.

Би тэгээд нийгэмд бас төөрөгдөл байгаа учраас Старлинк/Starlink/, Чингиссат хиймэл дагуул хоёрын ялгааг ярих ёстой юм шиг байна. Тэрнээс биш зарим энэ жиргээ дээр ярьж байгаа бас мэдэмхий хүмүүс их олон байгаа учраас тэр энийг бас хэлэх ёстой. Энийг бол дараа нь Анар гишүүн ч гэдэг юм уу энэ яг үндэсний энэ хиймэл, ер нь энэ ерөнхий ийм танин мэдэхүйн мэдээллийг бас би, бидний гишүүдэд бас өгөөд явбал тэрнээс биш яг Старлинк/Starlink/ байхад та нар яах гэж байгаа юм гэдэг ийм асуулт асуучихаар өөдөөс нь ингээд хариулахад бас их хэцүү болчихоод байна л даа. Бид нар чинь ингээд тэнгэр, газар хоёр шиг юм яриад байна.

Тэгэхээр Старлинк бол энэ их амаргүй юмыг давсан юм. Старлинкийг бол Ерөнхий сайд Элон Масктай нэг уулзалт хийсэн. Түүний дараа бид нар Харилцаа холбооны хуульд өөрчлөлт оруулсан. Харилцаа холбооны хуульд өөрчлөлт оруулаад нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг “Старлинк Монголиа” /Starlink Mongolia/ гэдэг Спэйс Икс /SpaceX/-ийн байгуулсан компанид Харилцаа, холбооны зохицуулах хороо хуульд өөрчлөлт орсны дагуу өгсөн юм.

Яагаад гэхээр манай Харилцаа холбооны хуульд хиймэл дагуул хөөргөсөн тохиолдолд, ялангуяа энэ харилцаа холбооны хиймэл дагуул хөөргөсөн тохиолдолд газрын станцыг заавал байгуул гэдэг ийм шаардлага Харилцаа холбооны хуульд байсан. Нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх дээр газрын станц заавал байгуулах шаардлагагүй гэдгийг хуулиар хийж өгөөд энийг хийсэн. Тэгээд тухайн үед тэр Эм Даблью Си/MWC/-гийн үеэр бид нар нөгөө Вань Веб/OneWeb/-тэй уулзсан. Одоо ер нь бол Спэйс Икс/SpaceX/, Старлинк/Starlink/ бол нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхэлж

байгаа нэг л компани. Энэ хуульд өөрчлөлт орсноороо бол тэр Вань Веб/OneWeb/ өөр өөр компаниуд орж ирэх бололцоо хуулиар нээгдсэн юм.

Яагаад гэхээр Старлинк/Starlink/-ийн гол ялгаа нь газрын станц байхгүй. Газрын станц байхгүй гэхээр бид нар удирдахгүй байгаа гэсэн үг. Шилэн кабелиар орж ирж байгаа интернэт броузер/browser/ дээр янз бүрийн линк рүү орох, янз бүрийн сайт руу орох дээр бид нар хязгаарлалт хийж чаддаг байсан. Тэгвэл Старлинк/Starlink/-ээр юу ч үзүүлсэн бай, ямар ч мэдээлэл дамжуулсан бай Монгол Улс хяналт огт тавьж чадахгүй байгаа шүү.

Яагаад гэхээр Старлинк/Starlink/-ийн газрын станц бол Японд байрладаг. Тэгэхээр манай хууль дээр газрын станц байгуулахгүй бол энийг зөвшөөрөхгүй гэхчхэн байсан.

Гэтэл энэ чинь нөгөө дэвшилтэт технологи ороод ирэхээр хууль дээр мянга ингэж хийлээ гээд бид нар энийг зохицуулж чадахгүй байсан. Тийм учраас тэр хуулийг өөрчлөлт оруулаад зохицуулах хороо зөвшөөрөл өгөхдөө тусгай зөвшөөрөл эзэмшигчтэйгээ эрх, үүргээ тохирсон. Та нар гэмт хэрэг сурталчилсан, садар самууныг сурталчилсан, үндэсний язгуур эрх ашигт сөргөөр нөлөөлсөн ийм байвал энэ дээр хязгаарлалт хийнэ шүү, энэ дээр хамтарч ажиллана шүү гээд. Үгүй бол тусгай зөвшөөрөл цуцална шүү ч гэдэг юм уу. Одоо бол Старлинк/Starlink/ хил, хилийн ойролцоо одоо энэ боомтуудаар Старлинк/Starlink/ ажилладаггүй. Яагаад гэвэл энийг хоёр хөрш зөвшөөрөхгүй байгаа юм. Энийг зөвшөөрдөггүй.

Тийм учраас алслагдсан боомтуудаар Старлинк/Starlink/ тавих бололцоо байхгүй.

Хоёрт, төлбөр мөнгийг нь энгийн нэг малчин айл дийлэхгүй ийм л байдалтай байгаа. Тийм учраас Старлинк/Starlink/ анх орж ирэхэд

оператор компаниуд юу гэсэн бэ гэхээр энэ бид нарын бизнест харшлах юм байхгүй юм байна. Яагаад гэвэл хот суурин газар шилэн кабелиар орж ирж байгаа интернэтээс угаасаа өрсөлдөх бололцоогүй үнийн хувьд. Тийм учраас суурин газар байгаа хүмүүс бол тэр шилэн кабелийнхаа интернэтээрээ аваад л явна гэдгийг бол хэлж байсан.

Тэгэхээр Старленк/Starlink/-ийн хувьд амьдрах хугацаа 5 жил, жингийн хувьд 260км-т, 550км-т л хөөрч байна гэсэн үг шүү дээ. Тэгээд жижиг. Манай энэ Чингиссат байвал энэ чинь нэйшнал сателлайт гэдэг бол өөрөө жингийн хувьд 3.5 тонн. Би тухайн үед “Талес Алейна” гээд бараг 31 хиймэл дагуулыг бүтээсэн Италийн оролцоотой Листэд Францын ТӨК. Энэ компанийн үйлдвэр дээр очиж тэр Нистэд очиж танилцсан. Тэгээд яг ингээд тухайн үедээ Филиппиний билүү юу билээ ингээд хиймэл дагуул бүтээснийг нь бид Индонезынхыг харсан. 3.5 тонн жинтэй. Энэ маш энгийнээр ингээд л нэг ийм толины тусгал шиг л ингээд л удирддаг юм байна лээ л дээ. Нэг ёсондоо тэр дээр байршаад л манайх руу ингээд л тусгалаа ингээд л харуулах юм байна лээ. Түүнийг нь бид нар төвд бай Наран станц тэр байгуулах газрын станцаасаа удирдаад 4 аймаг дээр байх газрын станцтай холбогдоод явна. Дахиад 2 гарц нь Япон руу, Франц руу. Францын 2 газрын станц руу холбогдоно гэж байгаа юм. Тэр гол онцлог нь бол олон тооны хиймэл дагуул хөөргөж тасралтгүй сүлжээ үүсгэдгээрээ энэ Старленк/Starlink/ ялгаатай.

Газрын станц нь Японд байдаг учраас мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. Хиймэл дагуулын удирдлага, хяналт найдвартай ажиллагаа, бусдаас хараат байдалтай, тэгээд хил орчмын бүсэд ажилладаггүй.

Чингиссат-ын хувьд нэг хиймэл дагуулаар дэлхийн нэг талын харагдах өнцгийг бүрэн бүрхэж байгаа юм. Нэг талын харагдах өнцгийг 4 ширхэг газрын

станц байгуулж 16 зоноор Монгол Улсын нутаг дэвсгэрийг интернэтийн сүлжээг хангана. Маш бага зардлаар хорин тэр есөн их наяд төгрөгийн зардлыг хэмнэнэ. Хиймэл дагуулын удирдлага, хяналтыг Монгол Улс өөрөө хийж аюулгүй байдлыг хангана, шилэн кабелийн сүлжээ тасрахад хиймэл дагуулуудаар бусад улс руу харилцаа холболт хийх сонголттой байгаа. Энэний гол нь юу вэ гэхээр шилэн кабель тасарлаа гэвэл бид нар Францын газрын станц руу холбох Япон руу бас нэг гарцыг хийж өгч байгаа гэхээр одоо дайны байдал ч байна уу, ийм ийм ийм асуудал бол ингээд үүсэхээр ямар нэгэн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зүйл байхгүй гэж ингэж үзэж байгаа.

Тэгээд газрын станц 4 байрлана. Улаанбаатараас Сансрын холбооны Наран станц гэж байгаа. Манай үе үеийн холбоочид манай энэ хуучны тэр холбооны яам анх байгуулагдаад улс орон даяар радио эрлээний станц байгуулагдаад ингээд хэрсэн сайхан сүлжээ хийж байсан, энэ цаг үед ажиллаж байсан энэ манай хуучны холбоочдын үргэлж санаж, бодож явдаг зүйл бол энэ үндэсний хиймэл дагуул. Готов сайд хүртэл өдөр тутам залгаж байна. Энэ бол үндэсний язгуур эрх ашиг шүү. Манайх шиг хоёр хөршийн дунд оришиж байгаа ийм улсад энэ язгуур эрх ашиг шүү. Тийм учраас энэ чухал гэдгийг байнга хэлж байгаа.

Ингээд нөөц төвийг Дархан хотод “Мэдээлэл холбооны сүлжээ” компани дээр байршуулна. Дээрээс нь энэ хиймэл дагуулын үйл үйл ажиллагааг авч явах нь мэдээж “Мэдээлэл холбооны сүлжээ” компанийнхаа үндсэн дэд бүтэц дээр бол ашиглая гэж байгаа. Мэдээлэл дамжуулах буюу нөгөө гэйтвэй/geteway/ газрын станц бол 4 байна. Дорнод, Өмнөговь, Өмнөговь, Баян-Өлгий, Дархан гээд ийм 4 ийм гэйтвэй/geteway/ байна гэж үзэж байгаа.

Мөн энэ та бүхэн сая хэлсэн нөгөө тракин/tranking/ хийх буюу шилэн кабелийн сүлжээ тасарсан тохиолдолд



Үндэсний хиймэл дагуулаа ашиглан гуравдагч хөршийн нутаг дэвсгэрт байрлуулах газрын станцаар дамжуулж интернэтийн олон улсын гарцтай холбогдоно. Үүнийг ТЭЗҮ дээрээ Францын мэдлийн газар нутагт байх 2 цэгийн аль нэгд байгуулах шийдлийг санал болгож байгаа юм. Тэгээд ингээд транк/tranking/-ыг нь хийнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Бий болох шууд нөлөө бол Монгол Улс хаанаас ч интернэт боломжтой болно нэгд. Энэ бол коммуникэйшн сателлайт/communication satellite/, Старлинк/Starlink/ бол харилцаа холбооны хиймэл дагуул мөртөө олон ийм жижиг хиймэл дагуул хамтарч ажилладаг хяналтгүй байна гэсэн үг. Бидний удирдлага нь биш. Өнгөрсөн хугацаанд хийж байсан тэр зарим нь бүр ингээж асууж байна шүү дээ. Мазаалай гээд хиймэл дагуул хөөргөө биз дээ гэж. Энэ чинь зүгээр шинжлэх ухааны тандан судалгааны хиймэл дагуул, нэг ийм жижигхэн хэмжээний хиймэл дагуул хөөргөсөн. Одоо манай Анар гишүүн бол тэр “Өүл-1”, “Өүл-2” гээд ийм хиймэл дагуулыг энэ тандан судалгааны хиймэл дагуул байна гэж би ойлгоод байгаа.

Мэдээж энэ чинь бас хөгжиж дэвшиж явж байна. Гэхдээ үндэсний хиймэл дагуултай болсноороо энэ олон шинжлэх ухааны тандан судалгаа хийх, сансар судлал хөгжих, сансрын эдийн засаг гэдэг ойлголт хөгжихөд аягүй их тустай. Жишээ нь, Монгол Улсын Ерөнхийлөгчийг АНУ-ын Дэд ерөнхийлөгч тэр Камала Харрис урихдаа ганц л чиглэлээр хамтарч ажиллая гэсэн. Сансар судлал, сансрын эдийн засаг, сансрын орон зайд ажиллах сонирхол байна л гэсэн. Өөр сэдэв байхгүй. Дэлхийн улс гүрнүүд бол одоо сансар гэдэг шинэ эдийн засагтай, шинэ бизнестэй, шинэ орон зайтай болчихсон. Хятадаас бол бид нар санал тавиагүй биш. Рэгдэл гуай бас хэлж байна лээ. Хятадууд бол үндэсний хиймэл дагуул хөөргөхөд тусалъя гэж байгаа. 50 хувийн буцалтгүй тусламж ярьж байгаа.

Гэхдээ “Роскосмос”-той олон жилийн хамтын ажиллагаатай Монгол Улс Оростой хамтраад сансрын нисгэгч хөөргөж байсан. Тэр байтугай дахиад монгол эмэгтэй сансрын нисгэгч хөөрнө гээд дээд түвшинд уулзалт хийгээд тохирчихсон яваа улс Хятадаар хиймэл дагуулаа хөөргөнө гэвэл энэ Төв Азид, энэ хоёр их гүрний дунд оршиж байгаа улсыг хүлээж авахад бэрхшээлтэй үнэндээ. Энэ геополитикийн энэ том асуудал юм. Тийм учраас бол энэ өөрөө сонголтын хувьд би бас зөв гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Хоёрт бол 250 мянган малчин өрх одоо ингээд цахим үйлчилгээ, цахимжилт эрчимжих, тоо хуваагдал бууруулахад нэмэр болно. Мөн тусгаар бие даасан харилцаа холбооны системтэй шилэн кабелиас үл хамаарсан сүлжээгээр холбогдохоор нөгөө онцгой байдал, гамигийн үед, хил хамгаалахад, цагдаа, гаалийн гааль ч гэдэг юм уу тэр байтугай манайх чинь нэг хэсэг нүүрсний сонсгол хийгдээд л явж байхад нэг хэсгээс нүүрс алдагдчихлаа гээд л эхэлсэн шүү дээ. Америкт сүүлд яг энэ нөгөө НАСА дээр очсон. Тэгэхэд НАСА бол яг тэр НАСА-гийн хиймэл дагуулаас бид нарт зураг харуулж байсан. Энэ бол Монгол Улс. Яг Улаанбаатар хот дээр хар цэг байж байгаа энэ бол агаарын бохирдол, энэ бол танай нөхцөл байдал, энэ бол модны тоо энэ тэр гээд бүр ингээд нарийн юм үзүүлж байгаа шүү дээ энэ чинь. Тэгээд энэ чинь гамигаас хамгаалах, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, одоо 21 дүгээр зуунд хүүхэд алга болоод олдоггүй, 21 дүгээр зуунд малчид зудад очоод зудад ингээж нэрвэгддэг, хүн алтан амиараа хохирдог, тэгээд гэмт хэргийн илрүүлэг гэдэг чинь маш олон өндөр ач холбогдол байгаа. Ингээд аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг хангасан үйлчилгээ нэвтрүүлж, бизнесийн үйл ажиллагааг дэмжинэ гэж ингээж үзэж байгаа.

Дээрээс нь 5 Жи/5G/, Ай Өү Ти ЛОТ/ зэрэг шинэ технологиудын

нэвтрэлтийг дэмжинэ. Одоо ер нь бол сая Хот, тосгоны хууль дээр ч хүртэл юмсын интернэт ашиглахыг хуульчилж өгсөн. Тухайн үед би бас тэр ажлын хэсгийг ахалж байхдаа. Хотыг ухаалгаар төлөвлөе гэвэл Ай Өү Ту/IOT/ л хэрэглэнэ, юмсын интернэт ашиглая гэвэл интернэтийн хурд, хүртээмж, тоо хуваагдал. Тэгэхгүйгээр одоо юу сансар яриад байна, хиймэл дагуул ярьж байхаар тог, цахилгаан ярья гэж. Тог, цахилгааны чинь өмнө холбооны асуудал яригдаад байгаа байхгүй юу. Бид нар энийг бас анзаарахгүй явж болохгүй. Хүн ер нь зовлон нүүрлээд ирэхээр л ойлгодог. Тэр Украин дээр ч гэсэн тухайн үед холбооны асуудал үүсэхэд л тэр Украины удирдлагууд чинь очиж Старлинк/Starlink/-д санал тавиад эхэлж байгаа шүү дээ. Энэ чинь хиймэл дагуул байхгүй бие даасан харилцаа холбооны тусгаар байдал байхгүйтэй л холбоотой.

Ингээд мэдээж түрүүний хэлсэн нөгөө транкин/tranking/ буюу хоёр хөршөөр дамжин интернэт холбогдох сүлжээ гэмтсэн тохиолдолд өөрийн үндэсний бие даасан гарцтай болно гэж. Энэ ТЭЗҮ Япон улсын “Падеко” компани 2013 онд хийсэн Үндэсний сансрын холбооны болон тандан судалгааны ТЭЗҮ. Энэ ТЭЗҮ-г бид нар шинэчлээд санхүүжилтийг нь үр ашгийг нь нэмэгдээд, нэмээд шинэчлээд ингээд сая ТЭЗҮ-гээ баталж байгаа.

Би үнэ хөлсний талаар бас хэлье. Нийт 212 сая евро. Хиймэл дагуулын үйлдвэрлэл, хиймэл дагуулын үндсэн бүтэц, Кэй Юү зурвасын систем, дижитал хөрвүүлэгч процессор гээд багтдаг юм байна лээ. Газрын станцын тоног төхөөрөмжүүд багтсан. Энд нөгөө хяналтын өрөө, тоног төхөөрөмжүүд, гэйтвэй/geteway/, удирдлагын хяналтын төв, сургалт болон бусад үйлчилгээ гээд нөгөө хүний нөөцийг бэлтгэх тэгээд транкин гэйтвэй/tranking geteway/ энэ б.б гээд.

Нэмэлт зардал. Ингээд энэ бол маш энгийнээр бол хиймэл дагуулыг

Франц бүтээж өгнө. Тэгээд Францад бид нар хүсэлт тавьсан. 2027 он гэхэд хөөргөе. Тэгээд нөгөө листэд, очерт оръё гэсэн Ай Ту Ю/ITU/-дээ бол бид нар яг нөгөө очер дарааллыг ярих тийм бололцоо байхгүй байна. Манайхаас олон хиймэл дагуул бүтээж байгаа гэсэн. Тэгээд түүний дараа Америкт Спэйс икс /SpaceX/ дээр уулзахдаа бид нар бас санал тавьсан. Бидний бүтээсэн хиймэл дагуулыг пуужиндаа хийгээд хөөргөх ажлыг нь та нар зохион байгуулаач гэсэн. Тэд бол боломжтой гэдгээ илэрхийлсэн. Японд бол санал тавьсан. Япон бол бас боломжтой гэдгээ илэрхийлсэн. Энэ аль аль улсаар хиймэл дагуулаа хөөргөх вэ гэдгийг бүрэн шийдээгүй байна. Тэгэхдээ Япон, Америк хоёрын нэгээр нь хөөргөнө. Спэйс икс/SpaceX/-ийн пуужинд хийж хөөргөж болно, Японтой хийж болно. Үнэ хөлсний хувьд бол Спэйс икс/SpaceX/ нь арай хямд зардалтай гэж үзэж байгаа. Тэгээд 27 онд хөөргөнө гэж ингээж зорьж байна.

Энэ дээрээс бол хөрөнгө оруулалтын зардал, санхүүжилт ийм өндөр харагдаж байгаа.

Гэхдээ шилэн кабелиар улс орноо интернэтээр өрье гэвэл 29 их наяд. Ингээд хиймэл дагуул бүтвэл ийм боломжтой. Дээрээс нь компанийн нууц учраас ДДИШ, Монсат энэ тэр гээд компаниуд байгаа. Одоо хөдөө олон суваг үзэж байгаа. Жишээ нь, ДДИШ-ийн антенныг дээшээ харуулаад олон суваг үзэж байгаа чинь хиймэл дагуулаас авч байгаа, Монсат гээд байхад ингээд хиймэл дагуулаас авч байгаа. Хувийн бизнес учраас яг тоо бол хэлэхгүй байгаа. Гэхдээ энэ компаниуд Кореансат/Koreansat/-д төлдөг төлбөрөө. Нэг ёсондоо нөгөө Кэй Ту/КТ/ компани бид нар уулзаж байсан. Кэй Ту/КТ/ компани өөрийн Кореансат/Koreansat/ гээд Солонгосын хиймэл дагуулыг хөөргөсөн. Энэ хиймэл дагуулд манай ДДИШ, Монсат төлбөрөө төлдөг. Энэ чинь хэд болж байна гэлээ жилд? 9.6 сая доллар төлдөг гэж байгаа юм. Тэгэхдээ энэ бизнесийн нууц учраас

нарийн хэлэх бололцоогүй. Тэгэхдээ энэ 2.5 дахин өснө гэдэг ийм тооцоололтой байгаа юм. Тэр 9.6 гэхээр бид нар эхний жилээ гэхэд 2 дахь жилээсээ дотоодын энэ компаниуд бол дотоодынхоо хиймэл дагуул төлбөрөө төлөөд ажиллая гэдгээ илэрхийлж байгаа. Энэ дээрээ бол мэдээж Солонгосын хиймэл дагуулаас арай төлбөр мөнгийг нь багаар санал болгоод ингээд ажиллахад бид нар жилд 9 гэж бодоход ингээд зардлуудаа нөхнө гэж тооцож байгаа.

Дээрээс нь энэнээс нөгөө дан бусаар, шууд бусаар бол маш их боломж гарч ирнэ. Шууд бусаар манай энэ хиймэл дагуул, тандан судалгааны хиймэл дагуул бүтээж байгаа компаниудад, эрдэм шинжилгээний салбарт, тэгээд л энэ чинь ер нь яг уул уурхайн салбарт маш том түлхэц болно. Уул уурхайн салбар гэхээр бид нар нөгөө ашигт малтмалын нөөцийг тодорхойлоход хүртэл хиймэл дагуулыг ашиглах бололцоо бий болно. Геологи, хайгуулын салбарт том дэвшил гарна. Тэгээд хүнс, хөдөө аж ахуйн салбарт бол маш том ахиц гарна, сансар судлал хөгжинө. Манайх шиг ийм орон бол яг ингэж далайд гарцгүй орон бол яг л ийм л замыг бид нар бол сонгох ёстой. Тийм учраас эрүүлээр энийг харах ёстой гэж байгаа.

Яах вэ танин мэдэхүйн ертөнцөөр зарим хүмүүс бас аялаад ингээд жиргээн дээр янз бүрийн юм бичиж байна. Улс орны эрх ашгийн төлөө асуудал болохоос биш энэ бол өөрөө цаг үе нь харуулна цаашдаа үндэсний хиймэл дагуултай болохын өндөр ач холбогдол юу вэ гэдгийг харуулна.

Тийм ч учраас эрхэм гишүүд та бүхнийг үүнд бас ухаалгаар хандаж өгөөч гэж би хүсэж байгаа. Энэ ТЭЗҮ бол ингээд нарийн зардлуудыг нь та бүхэн өөрсдөө бас хараад яваасай гэж би бас бодож байна. Зүгээр ер нь бол энэ Японы “Падеко” компанийн хийсэн ТЭЗҮ-г шинэчилж сая Сансарын зөвлөлөөр ингээд батлуулсан. Тэгээд энэ ажлыг хийхэд яг үнэндээ бас тийм амар

бас байгаагүй. Энэ бол сүүлийн 2 жилийн хүч хөдөлмөр явж байж явж байгаа.

Санхүүжилтийн хувьд бол 15 хувь нь төсвөөс, 85 хувь нь хөнгөлөлттэй зээл. Түүний хэд нь нэн хөнгөлөлттэй билээ? 82 сая нь нэн хөнгөлөлттэй зээл. Ингээд 15 жил гэдэг боломжийг Франц бид нарт олгосон. Хоёр Сангийн яамны хэлэлцээр явсан. Бид нар бол энэ төслийг бол санхүүжилтээ бол нөхөөд явна гэдэгтээ эргэлзэхгүй байна.

Хоёрт бол манай энэ чинь хоёр Ерөнхийлөгчийн төрийн айлчлалын үед хийгдсэн байхгүй юу. Эхлээд Монголд Францын Ерөнхийлөгч ирсэн. Тэгээд үүнийх нь хооронд бид ажиллаж байгаад Францад Монгол Улсын Ерөнхийлөгч очиход хоёр Ерөнхийлөгчийн өмнө энэ “Талес” компанидаа санамж зурсан. Тэгээд ингээд процесс явсан. Төсвөөс сая 15 хувь буюу энэ 68 тэрбумыг тавьж байхаар Франц бол үүнд ингээд Монгол Улс үүргээ биелүүллээ, бид нар ажлаа эхэлж гэдгээ хэлж байгаа. “Талес” бол листэд компани, нээлттэй компани. Дээрээс нь энэ чинь Францын төрийн өмчит мөртөө Итали оролцоотой. Тэгэхээр энэ бол олон улсын листэд компани, турилагатай компани. Монголд бол тэр “Голомт” банк, хэд хэдэн газар бол бас олон төсөл хэрэгжүүлж ирсэн турилага бол бас байдаг юм байна лээ. Нэлээн удаан өрнөсөн.

Ингээд энэ бол нөгөө геополитикийн хувьд Францыг сонгох нь арай зохимжтой юм гэдгийг Аюулгүйн зөвлөл дээр ч ярьсан. Сансарын зөвлөл дээр ч ингээд ярьж байгаа юм. Тэрнээс биш бид нар Энэтхэгтээ хийсэн бол аналог технологи хуучин технологи. Геополитикийн хувьд маш их тохиромжгүй байгаа. Яг Энэтхэгтээ хийхэд. Та бүхэн бас мэдэж байгаа. Шууд Америктай бол бас их геополитикийн хувьд тохиромжтой юу, үгүй юу бас бэрхшээлтэй. Ингээд Орос, Хятадаас аль нэгээр нь хиймэл дагуул бүтээлгэнэ гэдэг бэрхшээлтэй. Тэр

Сансрын зөвлөл дээр бид нар хоёр хөршийнхөө бас мэдээж сансар чиглэлээр хамтарч байгаа үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд “Роскосмос”-той хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ, эмэгтэй сансрын нисгэгч хөөргөнө, Хятадтай ч гэсэн тандан судалгааны хиймэл дагуулыг нь дэмжинэ гээд ингээд явж байгаа.

Японтой бол сургалт, судалгаа, энэ кибер аюулгүй байдал чиглэлээр ажиллаад ирчихсэн. Спейс икс/SpaceX/ дээр Старлинк/Starlink/-ийг нь хуульдаа өөрчлөлт оруулаад дэмжчихсэн. Тэгээд гео политикийн хувьд ингээд зохимжтой үе таарсан.

Дээрээс нь сая бас ОХУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилсан. Ингээд тэр тухайн хэлэлцээрээр ч гэсэн сансар судлалаар ажиллая гэдгээ илэрхийлж л байгаа. Тэгээд ийм үед Францтай хиймэл дагуулаа бүтээх нь ийм цаг хугацааны ийм нэг цонх, зөв үе бас таарсан гэдгийг бол бид нар бас алдаж болохгүй гэж ингээж бодож байгаа юм. Яг ийм нэг цонх үе. Тэрнээс биш энэ удаан хугацаанд үргэлжилбэл маш хүндрэлтэй байдал бол үүснэ.

Хоёр хөршийн зүгт бол Ай Ти Ю-ийн өгсөн байришил дээр бол аль ч улс оролцох тийм төдийлөн эрх бол байхгүй. Хувийн хэвшлийн компаниуд бол хиймэл дагуул бүтлээ гээд бизнест нь сөргөөр нөлөөлөх юм бол огт байхгүй. Яагаад гэвэл суурин газар интернэт хэвээрээ л байна. Энэний үнээс хямдхан байна гэдэг ойлголт байхгүй. Зөвхөн алслагдсан сум, суурин, багууд, малчдад, тэгээд үндэсний аюулгүй байдал, тэр онцгой байдал, гамшиг, хил хамгаалах гээд ийм салбаруудад энэ үндэсний хиймэл дагуул ашиглагдана. Дотоодын компаниуд үндэсний хиймэл дагуулаа төлбөр мөнгөө төлөөд, үйл ажиллагаагаа өргөжүүлээд бизнесийн хувьд ингээд өргөжүүлээд явах бололцоо бас эндээс байгаа.

Тэгэхээр дээрээс нь бид нар бол Засгийн газар дээр нөгөө 14 мега төсөл дээр энэ хиймэл дагуулыг оруулсан. Санхүүжилтийн хувьд тийм мега гэж хэлж болохуйц өндөр биш ч гэсэн энэ бол шууд бус утгаараа маш олон ашигтай байгаа гэдгээр нь ингээж оруулсан. Дээрээс нь Францтай бид нар нөгөө “Орона”-гийн хөрөнгө оруулалтын гэрээг одоо байгуулах ажил өрнөж байгаа.

Тийм учраас ер нь энэ Франц улстай мэдээж “Орона”-гийн гэрээ байгуулах, энэ том төслүүдийг явуулах ажил үргэлжилж байгаа учраас Франц бол бас 85 хувьд нь хөнгөлөлттэй зээлийг бас олгоё гэдэг ийм шийдвэрийг гаргаад явж байгаа. Тэгэхээр ер нь процесс бол Их Хуралд бид нар энэ зээлийн хэлэлцээрийг өргөн мэдүүлнэ ингээд ажил бол үргэлжилнэ гэж байгаа. Цаад талын хугацаа бол 27 оны 2 дугаар улиралд гэхэд бол хөөргөнө гэсэн ийм цаг хугацааны төлөвлөгөө бол бас байгаа гэдгийг хэлье. Мэдээж хэлэлцээрээ баталсны дараа энийг Сангийн яам зээлийн хэлэлцээрээ зураад ингээд явна. Төсөл хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, “Мэдээлэл Холбооны сүлжээ” компани тэгээд эд нар ингээд энэ үйл ажлаа өргөжүүлнэ.

Миний хувьд бол энэ нэгэнт бас салбар дундын асуудал, зээлийн санхүүжилтийн асуудал, мэргэжлийн асуудлууд байгаа учраас зүгээр ажлын хэсгийг ахлаад явж байна. Баатархүү сайд бол Дэд даргаар ингээд ахлаад ингээд явж байгаа. Зээл энэ ажил өрнөөд яг хэрэгжүүлэх байгууллага үйл ажиллагаа нь Цахим хөгжлийн яаман дээр төвлөрөөд явна гэж бол ойлгох ёстой.

Өнгөрсөн хугацаанд инженер техникийн ажилтнууд энэ газрын станцуудыгаа ирж үзсэн, хэд хэд үзсэн. Монголд ч гэсэн ингээд гэсэн. Одоо яг энэ цаг мөчид бол бас ажиллаж байна. Тэгээд энэ бас дэлхий дахинд маш том

цохилт болох ийм том алхам учраас та бүхэн бас тэр Старлинк/Starlink/-тэй ч гэдэг юм уу хольж хутгах бас шаардлагагүй байх гэдгийг л та бүхэн маань сайн бодоорой. Энэ бол бас үндэсний аюулгүй байдал шүү. Тэгээд та бүхнийг үүн дээр бас ухаалаг хандана гэдэгт би бас итгэлтэй байна. Тэгээд ийм мэдээлэлтэй байна. Өнөөдөр ажлын хэсгийнхэн, Цахим хөгжлийн яамныхан ирсэн учраас яг мэргэжлийн асуултууддаа бас хариулаад явах байх гэж бодож байна.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Асуултад хариулах мэдээлэл өгөх зорилгоор ирсэн ажлын хэсгийнхнийгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Баатархүү ирсэн байна, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ганбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Золбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цагаанхүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Эрдэнэ? Байхгүй юу тээ? Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Би өөрөө төгсгөлд нь асууна. Ингээд 2, Пунсалмаа гишүүнээр тийм тасалъя. 2 гишүүн асуулт асуухаар нэрээ өгсөн байна. Анар гишүүн асуултаа асууна уу.

**Ч.Анар:** Сайн байцаана уу? Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн ахлагч Учрал сайд болон Баатархүү сайддаа баярлалаа.

Энэ дээр би эхлээд өөрийнхөө дүгнэлтийг нэг хэлээд, дараад нь асуулт асууя гэж бодож байна.

**Ж.Золжаргал:** Уучлаарай хугацаатай учраас та асуултаа, үг хэлэх дараа нь дахиад тусдаа байгаа.

**Ч.Анар:** Ойлголоо. Тэгэхээр нэгдүгээрт энэ технологийн хувьд болохоороо хиймэл дагуул, би өөрөө 24 жил энэ салбарт 3 улсад хиймэл дагуул угсарч байсан туршилагатай инженер хүн. Тэгэхээр энэ талаасаа харах юм бол Учрал сайдын танилцуулж байгаа малчин өрхөд интернэт хүргэнэ, 5 Жи /5G/, Ай өв Ти/IoT/ цаг агаар, гамшиг энэ олон төрөлт хиймэл дагуул дэлхий дээр хаана ч байхгүй. Тэгэхээрээ тийм байгаа дээр нь тодорхой нээлттэй мэдээлэл хүргэхгүй бол дараад нь энэ маань өөрөө хэрэгжихгүй бол асуудал үүснэ. Тэгэхээр ямар хиймэл дагуул болохоороо тийм хиймэл дагуул байгаад байгаа юм бэ?

Дараагийнх нь асуудал бол малчдад 260 мянган малчдад энэ интернэтийн үйлчилгээ хүргэхэд өндрийн хиймэл дагуул маань маш том. Одоогийн Кей Юу Банд/Ки-band/ буюу 200 мегагерцийн зурвасаар харах юм бол 1.2-оос 1.4 метр тавган антенаар интернэт орно. Энэ нь өөрөө хэрэглэгчийн терминал нь өндөр өртөгтэй. Дээрээс нь ДДИШ-ийг бодвол энэ чинь мэргэжлийн инженер тохируулдаг. Тэгэхээр энэ нь өөрөө малчин өрхөд хүртээмжгүй, эдийн засгийн өртгийн хувьд болоод технологийн хувьд. Тэгэхээр энийг мэргэжлийн хүмүүс нь тайлбарлаж өгмөөр байна. Энэ технологийг боломжтой болгохын тулд Старлинк/Starlink, Вань веб/OneWeb/, Телсат/Telesat/ гэсэн бүх хиймэл дагуулууд нам руу жижиг өндөр хүчин чадалтай хиймэл дагуулаар орж байгаа.

Гуравдугаарт, энэ “Талес” чинь өөрөө бол уламжлалт хиймэл дагуул хийдэг компани. Орчин үеийн хиймэл дагуулууд бүгд жижигхэн болоод бүгд нам орбит дээр ирж байгаа.

Дөрөвдүгээрт, үндэсний аюулгүй байдлын бодлого дээр 100 хувь санал нийлж байгаа. Манай дээр энэ зайлиггүй шаардлагатай. Гэхдээ ийм төсөвт өртгөөр хийх шаардлага байхгүй. Үнэхээр энэ дээр ийм төсөвт өртгөөр хийж байгаа цэргийн болон тагнуулын тусгай зориулалттай тоног төхөөрөмж байгаа юм уу? Тийм бол улсын нууцад хамаарах ёстой. Улсын нууцад байгаа гээд мэдээлэл өгөхгүй байгаа. Тийм бол улсын нууцад хамруулсан Засгийн газрын тогтоолоо үзүүлээч. Тэгэх юм бол энэ талаар хаалттай мэдээлэл авъя гэсэн байдалтай байна.

Эдийн засгийн хувьд бол үүрэн холбооны компаниуд энийг өндрийн хиймэл дагуулыг бакхолд ашиглахаа больчихсон. Дэлхий даяараа больчихсон. Мобиком хамгийн сүүлийн хиймэл дагуул өндрийн хиймэл дагуул сат-аа ашиглаж байгаа. 25 онд буулгаж байгаа. Учрал сайдын хувьд өмнө нь хийсэн сайдын ажлын сайн үр дүнгийн ачаар бүх сумд.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Нэмэлт минутыг нь өгнө үү.

**Ч.Анар:** Тэгэхээр интернэт орсноор интернэтийн хиймэл дагуул маань үүрэн холбооны баг руу интернэтийг хүргэх зардлыг улам нэмдэг. Тэгэхээр энэ бол хоорондоо авцалдахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр дахиад ДДИШ, Монголсат гэсэн нийтдээ яах вэ ДДИШ 330 мянган хэрэглэгчтэй, Монголсат 115 мянган хэрэглэгчтэй, нийтдээ 440 орчим мянган хэрэглэгч дайракт хом/direct home/ буюу үйлчилгээг Монгол даяараа авдаг. Энэ зах зээл өсөхгүй ханачихсан. Энэ дээр үндэсний хиймэл дагуулыг ашиглах юм бол өртгийн хувьд Кореасат/Koreasat/, Телсат/Telesat/-тай гадаадтай өрсөлдөж чадахгүй. Энэ хэд 15 жилээр төлбөрөө хийчихсэн. Тэгэхээр улс энэ дээр нь дараа нь татаас өгч үндэсний компаниуддаа бага өртгөөр үйлчилгээ

хүргэх юм уу? Энэ асуултуудыг асууя. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Асуултад хариулах Золбаяр дарга, 5 дугаар микрофон өгье.

**Ч.Золбаяр:** Ажлын хэсгийн гишүүн. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Золбаяр, Анар гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, мэргэжлийн талаасаа Ай Ю Ти/ITU/, 5 Жи сенсор/5G sensor/-ууд бүгдээрээ нэг төхөөрөмжид суурилагдсан байна гэдэг зүйл байхгүй гэдэг нь ойлгомжтой. Би танд яг мэргэжлийн хүний талаас нь бас энийг хэлье. Энэ хиймэл дагуулаар бид юу бий болгох гэж байгаа вэ гэхлээр одоо яг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ бий болгодог шиг бид орон даяар таранкин/tranking/ сүлжээгээ бий болгож өгч байгаа гэж бас нэг талаас нь та ойлгож болно. Яг 10 гига-гийн сүлжээ үүсэж байгаа учраас. Энэ чинь 10 гига-гийн багтаамжтай хэрэглэгчийн сүлжээ бий болно. 0.75 метрийн антентайгаар “Монголсат” компани буюу “Исатком” компани яг Ви сат-ын интернэтийн үйлчилгээг хийж байгаа. Бид нар өөрсдөө тэр дээр нь туршилтуудаа хийсэн. Ер нь бол 2-5 Мегагийн хурдтайгаар бол Ай Ю Ти/IUT/ телевизүүд бол бүгдээрээ явж байгаа. Бид нар Вүү/Voo/-г нь ч тавьж үзсэн, Лүүк/Look/ тв-г ч тавьж үзсэн, бусад бүх Юү Түб/ You Tube/-ийг ч гэсэн бид нар хэрэглээг нь даунстрийм/downstream/ тал дээр нь бүгдийг нь харсан байгаа. Тэгэхээр энэ дээр 2-оос 4 мега дээр бол “Эйч Ди” сувгийн телевизүүд бол явж байна лээ.

“Талес” компани дээр, энэ сонгогдож байгаа хиймэл дагуулын асуудал дээр бол энэ дижитал трансформ платформтой ийм хиймэл дагуул байгаа. Энэ бол технологийн хувьд бол хоцорсон гэж хэлэхэд арай биш байгаад байгаа юм. Энэ гео стационар орбит дээр 15 жилээс дээш хугацаанд ажилладаг энэ өндөр орбитын хиймэл дагуул маань бол нам орбиттойгоо

харьцуулахад бол нэлээд хэдэн ялгаатай байгаа. “Талес” компани ч гэсэн нам орбитын нэлээн олон хиймэл дагуулыг хийдэг, Европын холбооны улсад яг энэнтэй манай Монгол Улсын нөхцөл байдалтай төстэйгөөр Европын холбооны улсууд хоорондоо нийлээд “Айрис 2” гэдэг системийг хөгжүүлээд бас явж байгаа. Энэний хүрээнд бол нийтдээ 170 орчим нам орбитын хиймэл дагуулаар Европын холбоон дээр яг одоо бид нарын үүсгэнэ гээд яриад байгаа энэ боломжуудыг үүсгэх харилцаа холбооны системийг бий болгохоор ингээд ажиллаад эхэлчихсэн явж байгаа. 2027 онд дуусгана гээд хэлчихсэн.

Энэ маань бол энэ 170 нам орбитын хиймэл дагуулын хийж байгаа төсөвт өртөг нь бол 5 тэрбум Еврогоор энэ босож байгаа ийм төсөл байгаа. Харьцуулаад хэлэхэд, Лео орбит нь бага өндөрт байдаг. Мэдээлэл дамжуулах хурдын хувьд, мөн үйлдвэрлэх процесс хялбар байх боловчиг энэ маань амьдрах хугацааны хувьд 5 жил болоод унадаг учраас тасалдаггүй байхын тулд бид нар нөхөж тэр байриил дээр нь дахиад 5 жилийн хугацаатай тэрийг хөөрөх ийм шалтгаан бий болно.

Дараагийн нэг юун дээр нь тэр зөвхөн нам орбитоор транкин/tranking/-гаа шийдэж байгаа гэдэг бол энэ бол технологийн дараагийн чиглэлийн асуудлууд байгаад байгаа. 6 Жи/6G/-гийн асуудал дээр мэдээж энийг ярьж байгаа. Элон Маск гэсэн Теслагийнхаа гар утсаар бид нар үүгээр ярьдаг болно гэсэн ийм юм хэрэгжээд явж байгаа. Энэ бол мэдээж технологийн хөгжлүүд явж байгаа.

Гэхдээ өндөр орбитын геостационарын энэ хиймэл дагуул бол сүүлийн хэдэн жилдээ, сүүлийн 10, 20 жилдээ устахгүй. Энэ яг 10 хэдэн жилийн өмнө байсан яг үндсэн платформ болон бусад тэр хиймэл дагуулыг тухайн байриил дээрээ байлгаж байгаа шингэн түли болон бусад асуудалтай холбоотой асуудал нь шийдэгддэг, шинэчлэгдэж

инновац нь айхтар гарч ирээгүй учраас яг энэ технологи дээрээ байна. Гагцхүү тэр.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Золбаяр даргад нэмэлт 1 минут.

**Ч.Золбаяр:** Тэр “спэйс...4000 би” гэдэг энэ платформ дээр суурилж байгаа өөрөөр хэлэх юм бол ракун дотор суурилж байгаа төхөөрөмжүүд маань софтвер дефайнд/software defined/ буюу манайх программ хангамжийн удирдлагатай уян хатан боломжтой ийм хиймэл дагуулыг хийгдэж байгаа. Энэ маань бол 2019 оноос дипло болоод хэрэглээнд ороод эхэлчихсэн хай труппут сателлайт байгаа. Ер нь бол манай энэ төслийн нэг онцлог нь юун дээр байна гэхлээр ажлын хэсгийн гишүүний хувьд нь хэлэхэд 100 хувь Европын холбооны улсуудаас хөнгөлөлттэй зээлээр ингэж хиймэл дагуулыг нь 100 хувь үнийг нь төлөөд дээр нь хай труппут сателлайт нэйинал хиймэл дагуулынхаа хэрэгцээг хангасан энэ дэлхийд хамгийн анхны тохиолдол байгаа юм манай энэ төсөл.

**Ж.Золжаргал:** 4 номер Учрал сайд нэмэлт хариулт өгнө.

**Н.Учрал:** Энэ бол би зүгээр санаанд орсноо яриад байгаа чинь бас биш л дээ. Энэ чинь Японы тэр “Падеко”-гийн ТЭЗҮ дээр шинжлээд энэ Францын энэ инженер, техникийн ажилтнууд ажиллаад, мэргэжлийн зөвлөлөөр нь оруулаад тэгээд л батлаад л явж байгаа юм. Ийм л төсөл л дөө. Тэгээд дээрээс нь энэ компани чинь нэг их тийм анх удаа туршилт хийх гээд байгаа компани бас биш л дээ. “Талес Алейна” гэдэг чинь дэлхийн нээлттэй том компани шүү дээ. Тэгээд хоёр Засгийн газар хоорондын хэлэлцээр л явж байгаа юм. Ийм л ажил.

Тэгээд ямар ч байсан улс орныхоо өнцөг булан бүрд интернэттэй болох бололцоо эндээс бол бүрдэнэ. Тэрнээс биш энд би нэг тийм гэнэт сэрчхээд нэг ийм яриад байгаа юм бас биш. Тэгээд энэ

надтай, надгүй өмнө нь ч гэсэн олон жил яригдаж байсан хиймэл дагуултай болъё гээд олон удаа үзээд тэгээд төдийлөн амжилтад бас хүрч чадаагүй. Ингээд явсаар ирсэн.

Тэгээд тэр Баттулга Ерөнхийлөгчийн үед ч гэсэн Энэтхэгтэй нэг Аюулгүйн зөвлөлийн зөвлөмж гараад л тэгээд л ингээд эхлэх гээд тэгж байсан наадах чинь аналогий байна гээд л санхүүжилтийн хувьд ч гэсэн манайд зээл, тусламж өгөх дээр бол бас тийм бодитой шийдвэр гараагүй. Тэгээд энэ удаа бол би хэлж байгаа л даа геополитикийн хувьд, дээрээс нь санхүүжилтийн механизм, схемийн хувьд, дээрээс нь технологийн хувьд тэр Энэтхэгээс ч байна уу, Оросоос ч байна уу, Хятадаас ч байна уу чухал яриа хэлцэл өрнөжээ. Тэгээд ийм цаг хугацааны хувьд ингээд явуулаад хиймэл дагуулаа бүтээлгэх нь чухал ийм цаг үеийг алдаж болохгүй л гэж бодож байгаа. Тэрнээс биш Анар гишүүн бид хоёр хиймэл дагуулыг мэддэг, мэддэггүйгээрээ яривал энд их өөр юм болно л доо. Тийм учраас би таныг 24 жил энэ салбарт ажилласан сансрын судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа үнэтэй хувь нэмрийг.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Нэмэлт цаг өгнө үү 4.

**Н.Учрал:** Таны үнэтэй хувь нэмрийг би өндрөөр үнэлсээр ирсэн. Тэгээд сансрын үндэсний хиймэл дагуултай болъё гээд арай гэж даваад та бид нар жил, 2 жил би танд энэ ажлыг л дүнд хүргэвэл та бидэнд энэ үр хүүхэд, хойч үедээ энэ түүхэнд үлдэх гавьяа байгуулна гээд их л олон ярьсан. Тэгээд ороод ирэхээр ийм юм яриад байхаар би гайхаад тэгээд яг энэ хиймэл дагуулыг та шүүмжлээд байх хүн нь мөн үү, биш үү? Хамгийн их дэмжих ёстой хүн байтал гэж би гайхаж байна. Энд бол ямар нэгэн тийм улс орондоо хэрэгцээтэй зүйлийг л харж ингэж ярьж байгаа гэдгийг ойлгох ёстой. Тэгээд зүгээр та хариулах хэрэгтэй Үндэсний

хиймэл дагуултай болох хэрэгтэй юу, үгүй юу нэгдүгээр бас асуултад хариулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, бол өөр ямар орноор, хэнээр, яаж хийлгэх вэ гэдгээ хэрвээ шаардлагатай гэвэл хийлгэх вэ гэдгийг олж ирэх хэрэгтэй. Тийм, тэрнээс биш би өөр юу хэлэх вэ. Тэгээд нийгэмд ялангуяа энэ сансар судлалаар, сансрын шинжлэх ухаанаар ингээд та нөлөө бүхий хүн зөв ойлголт өгөхгүй бол энэ нарийн та нарын энэ яриаг чинь бид нар мэргэжлийн бус хүмүүс бас сайн ойлгохгүй шүү дээ. Энэ нийгэм ч ойлгохгүй шүү дээ. Золбаяр та хоёр хоорондоо нэг ийм юм яриад. Хэрвээ ингэж яриад ингээд цаашилна гэвэл энэ төсөл явуулах хэрэггүй. Энэ мэдээж Их Хурлын шийдвэр.

**Ж.Золжаргал:** Анар гишүүний асуусан хоёр асуулт байгаа. Энэ төслийн хүрээнд энэ цэрэг, стратегитай холбоотой давхар даалгавар байгаа юм уу? Улсын нууцад хамрагдсан тийм тогтоол байгаа юу гэж нэгдүгээрт нь, хоёрдугаарт нь болохоор эдийн засгийн хувьд 10 жилийн дараа өртөг нь өндөр гарна. Тэгэхээр тэр нь цаашдаа татаастай явах уу гээд энэ дээр хариулт өгөх ажлын хэсгээс хариулт өгнө үү. 4 номер.

**Ц.Баатархүү:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ер нь Үндэсний хиймэл дагуул төсөл зөвхөн энэ Засгийн газрын үед юм уу, өмнөх Засгийн газрын үед яригдаагүй гэдгийг бүгд мэдэж байгаа. Энэ салбарт ажиллаж байсан олон хүмүүс хиймэл дагуултай болъё гэдэг энэ мөрөөдлийг биелүүлэх гэж туршилтын, нам орбитын тандан судалгааны хиймэл дагуулыг хүртэл Монгол Улс хөөргөж байсан. Үнэхээр энэ технологийн хувьд ямар юм бэ гээд нийгэмд гарч байгаа энэ байр суурийг нэгтгэх үүднээс энэ өөрөө түүхэн шийдвэр учраас, түүхэнд үлдэх учраас яам болон мэргэжлийн хүмүүсийг дуудаж хэлэлцүүлгүүдийг хийж байгаа. Яг энэ хиймэл дагуулыг түрээсэлж



ажилладаг бүх компанийн удирдлага, энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийг бид нар урьсан. Бид нар ойлголцолд хүрсэн. Үндэсний хиймэл дагуултай байх ёстой юм байна, Монгол Улс бол харилцаа холбооны бие даасан байдалтай болох ёстой юм байна гэдэг ойлголцолд хүрсэн гэдэг салбарын сайдын хувьд албан ёсоор мэдэгдмээр байгаа юм.

Учир юу юм бэ гэхээр яг энэ хиймэл дагуулаар үйл ажиллагаагаа явуулдаг, ашигладаг, дамжуулдаг энэ аж ахуйн нэгжүүдтэй бид нар уулзаж байгаа, салбарын бүх холбоотой уулзаж байгаа. Салбар өөрөө ойлголтын зөрүүтэй байвал Улсын Их Хурал дээр ойлголт тийм зөрүүтэй байна.

Тийм учраас салбар дотроо ойлголцъё гэдэг байдлаар техникийн шийдлүүдийг ярьж байгаа. Анар гишүүнтэй хоёр зүйл дээр санал нэг байгаа. Эд зүйлсийн интернэтийг дамжуулж байдаг технологи бол арай өөр эрчим хүч бага хэрэглэдэг. Гэхдээ дэлхий даяар технологи бол интернэт дамжуулах 5 үндсэн чиглэл технологийн хувьд шинэчлэгдээд явж байгаа. Өндөр орбитын технологи явж байна. Вайфай/WiFi/ 6 явж байна, 5 Жи/5G/ явж байна, шилэн кабель ч явж байгаа. Тэгэхээр Монгол Улсын хувьд өргөн уудам нутагтай, хоёр хөршийн дунд байдаг, хүн ам нь сийрэг байришилтай, харилцаа холбооныхоо тусгаар тогтнол, Монгол Улсын аюулгүй байдал, бие даасан байдлыг хангахад харилцаа холбоо бол стратегийн шинэжтэй юм байна. Энэ дээрээ энэ үндэсний хиймэл дагуул байх нь зөв гэдэг ийм зүйлийг мэргэжлийн хамт олон хэлж байгаа.

Тэгээд манай энэ салбарт байдаг мэргэжлийн холбоонууд, компаниудын төлөөлөл ч гэсэн бас Улсын Их Хурал дээр ирж энэ тухай ч гэсэн ярилцахад бэлэн байгаа гэдгийг би мэдээлэл өгөх үүднээс тайлбарыг хэлье. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** 4 номерын микрофон, Учрал сайдад нээж өгнө үү.

**Н.Учрал:** Үндэсний аюулгүй зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна. Тэрнээс биш ямар нэгэн тийм цэрэг, үүргийн тийм нууцад хамаарсан зүйл бол огт байхгүй. Би бол тэрийг бас хариуцлагатай хэлье. Ер нь маш энгийнээр сая Баатархүү сайд бас хэллээ л дээ. Тэгээд бид нар ер нь сансар дахь тийм нөгөө замаа л барьж байна л гэсэн үг. Тэр зам дээр ямар галт тэрэг явах юм, машин явах юм, юу явахыг бол тэр бол дараагийн асуудал. Ямар ч байсан замтай болж байна гэж ойлгож болно, дэд бүтэцтэй болж байна. Тэгээд л нэг их тийм томоор ойлгох биш юмсын интернэт гэдэг бол тэр эд зүйлсийг хооронд нь холбоод л ажиллуулах гэж байгаа л байгаа л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр тэр интернэтийн хүртээмжийг, интернэтийг нэмэгдүүлэхийн тулд л тэр замыг л бид нар бий болгож байгаа гэж л ойлгох ёстой. Тэрнээс биш тэр цаашидаа тэнд юмсын интернэтийг ашиглах уу, өөр өөр яг юу юу хийх вэ гэдэг бол бас дараагийн асуудал. Ямар ч байсан энэ замтай больё л гэдэг ийм л зүйлийг л эндээс бид нар шийдэж авах гэж байгаа гэдгийг хэлье.

**Ж.Золжаргал:** Тэр татаасны хувь дээр танд мэдээлэл байвал хэлж өгөөч. Үйл ажиллагаагаа авч явахын тулд ер нь, 4 номер

**Н.Учрал:** Тэр бол хувийн хэвшил, Кореансат/Koreasat/ гэдэг компанитай ямар гэрээ хийчихсэн байгааг бид мэдэхгүй. Тэр бол хувийн хэвшил хоорондын асуудал. Ямар төлбөр мөнгөөр, хэдэн жилийн гэрээ хийчихсэн. Тэгэхээр ийм тогтвортой гэрээтэй байгаануудыг шууд зогсоогоод ингэдэг тийм юм бизнес рүү халдсан юм бол байхгүй л дээ. Мэдээж бизнесийн зарчмаараа манай төлбөр, манай санал болгож байгаа бүтээгдэхүүн хямд байвал тэгээд хэлэлцээр хийгээд тохиролцоод тэр компани сонгоод явахад мэдээж бизнес ашигтай л ажиллах зорилготой юм чинь тэр. Тэрнээс биш бид нар шууд

тулгаад л, одоо зогсоогоод заавал үндэсний хиймэл дагуул руу ор гэдэг ийм шаардлага тавихгүй.

Гэхдээ энэ Баатархүү сайд эд нар уулзалт хийхэд мэдээж төлбөр мөнгө, бүтээгдэхүүний хувьд давуу талууд байвал ингээд л ярилцаад ишидээд явъя л гэдэг ийм л саналаа бол тавьж байгаа шүү дээ.

**Ж.Золжаргал:** Анар гишүүн шаардлагатай бол 1 минут байгаа тодруулга, нэмэлт асуулт асуух. Анар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

**Ч.Анар:** Учрал сайдын асуултад хариулъя. Учрал сайд бол сансрын салбарыг өнгөрсөн хугацаанд маш сайн дэмжиж ирсэнд талархаж ирдэг. “Талес” гэдэг сонголтыг хийхэд ч гэсэн бид хоёр зөвлөж байсан. Тэгэхээр энэ нь үндэсний хиймэл дагуул хөөргөх дээр би яг 24 жил яг салбарыг эксперт, инженерийн хувьд 100 хувь дэмжиж байгаа, бодлогыг дэмжиж байгаа. Энэ дээр дахин дахин хэлье 100 хувь дэмжиж байгаа, экспертүүд ч дэмжиж байгаа. Гэхдээ зорилго нь аргаа зөвтгөхгүй.

Нэгдүгээрт үнэтэй байна. Яг энэ зорилгод бол төсөвт өртөг 120-оос 140 байх боломжтой. Тэр төслүүд нь урьд нь жилүүд байгаа.

Хоёрдугаарт, та бүхнийг мэдээллээр буруу хангаад байна. Түрүүн Золбаяр дарга өөрөө хэлж байна шүү дээ Засгийн газар өөрөө бүх юмыг чаддаг хиймэл дагуул гэж, та бүхэн мэргэжлийн биш хүмүүс би энэ дээр санаа зовоод байна. Засгийн газрын хувь заяа дээр санаа зовоод байна.

Хоёрдугаарт, Баатархүү сайдтай экспертүүд дэмжсэн гэнэ. Би тэр уулзалтын протокол надаа байгаа шүү дээ. Бүгд хиймэл дагуултай болохыг нь дэмжиж байгаа болохоос технологи дээр нь.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Анар гишүүн. Юу яах ёстой хугацаа, энэ хугацаа дууссан байх. Сүүлд нь үг хэлэх секиэйн байгаа. Хоёрдугаарт гишүүн өнөөдөр заавал хариулт хэлэх албагүй л дээ. Та сүүлд нь дүгнээд үг хэлэх хугацаан дээр бас хангалттай цаг байгаа.

Пунсалмаа гишүүний асуултыг сонсьё. Микрофон нээж өгнө үү.

**Б.Пунсалмаа:** Сайн байцаана уу? Энэ Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Манайх энэ цахим засаглалаараа дэлхийн 196 орны 43-д ордог юм байна. Тэгээд кибер халдлагаас хамгаалах байдлаараа 196 орны 103-д орж байна. Тэгэхдээ зэрэг одоо энэ үндэсний хиймэл дагуул хөөргөснөөрөө иргэдийн интернэт хэрэглээ илүү нэмэгдэх нь. Тэгэхлээр энэ кибер хамгаалалтаа бид нар яаж хамгаалах юм бэ? Энэ дээр ямар ер нь үндэсний аюулгүй байдал талаасаа илүү сайжруулах ямар төлөвлөгөө хэрэгжүүлэх вэ нэгдүгээрт?

Хоёрдугаарт, үндэсний хиймэл дагуул гэдэг бол технологийн хувьд бол манай Монголд томоохон алхам болох гэж байна. Энэ том алхам хийх гэж байгаа гэдэг бол энэ ямар эрсдэл үүсэж болох вэ? Энэ эрсдэлийг юу гэж бодож байна вэ? Тэгээд явцын дунд гэнэт төсөл удааширах, нэмэлт хөрөнгө оруулалт хэрэгтэй болох, эсвэл дахиж нэмж зүйл суулгах ийм хэрэгтэй, шаардлагатай зүйл гарч ирэх үү? Энэ дээр ер нь юу гэж бодож байна вэ? Энэ технологийн хувьд шинэ алхам болохлоор бид нар энэ дээр бас хэд дахин бодох хэрэгтэй байх.

Гуравдугаарт нь хиймэл дагуулын ер нь өөрөө энэ хөгжил нь сүүлийн үед дэлхийд бас нэлээд хөгжсөөд байгаа юм шиг байна лээ. Тэгэхлээр одоо бид нар ингээд төсөв батлаад энэ зээлээр хийгдэж байгаа ажил гэдэг чинь бид нар төлнө л гэсэн үг төлбөрийг нь. Энэ төлбөрийг төлөх үед чинь энэ угаасаа их өндөр төлбөртэй, өндөр хиймэл дагуулын

шийдэл болжээ гэдэг энэ яриа хэдэн жилийн дараа гарч ирвэл бас энд сууж байгаа энэ Байнгын хорооны гишүүд бид хэд бас ямар шийдвэр дээр бас ажиллаж байсан бэ гэж эргээж харах ийм шаардлагатай болж магадгүй. Тийм болохлоор энэ ирээдүйн технологи чинь жилээс жилд л ингээж өөрчлөгдөж байдаг. Энийгээ бас та нар юу гэж харж байгаа вэ гэсэн ийм 3 асуулт байна.

**Ж.Золжаргал:** Пунсалмаа гишүүний асуултад 3 номер Баатархүү сайдын микрофон нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** Пунсалмаа гишүүн маш зөв асуудлуудыг хөндөж байна. Баярлалаа. Ер нь Анар гишүүнтэй бас зөв асуудал хөндөж байна. Тэгэхдээ нэг зүйл байгаа шүү. Би өөрөө хурлыг удирдаж байсан учраас бүгдээрээ эсрэг байр суурь илэрхийлээгүй гэдгийг албан ёсоор хэлье. Энэ индэр дээрээс бид нар бие биедээ худлаа хэлээд яах вэ.

Хоёр зүйл дээр санаа зовж байгаа манай инженерүүд. Хэрэглэгч дээр ирэх өртөг яах вэ гэдэг дээр санаа зовж байгаа. Тэгэхээр ажлын хэсэг бол хэлэлцээр дуусаагүй байгаа учраас ажлын хэсэг бид нар ч гэсэн ийм шахалт үзүүлж байгаа. Хэрэглэгч дээр ирэх тэр төхөөрөмжийн хэмжээ ямар байх юм, өртөг ямар байх юм хиймэл дагуулын тухайд шүү. Зүгээр интернэт нь өөрөө 2019 онд шинэчлэгдсэн тоон технологи учраас хүчин чадлаа тохируулаад байх боломжтой юм байна лээ. Энийг бол интернэтээр ороод бид нар бүгдээрээ судалчихна.

Хоёрдугаарт энэ Францын компани өөрөө дэлхийн топ бараг 6 компанид ордог листэд компани юм билээ. Тэгээд ямар өртгөөр үйлдвэрлэж байгаа юм бэ гээд бид нар хардаж байгаа бол ер нь бусад улсад ямар өртгөөр нийлүүлсэн юм бэ гэдэг нь бас л нээлттэй байж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр одоо бол нэг тийм хурлын ширээний араас бие биеэ ингээд хардах шаардлагагүй, интернэтээр бид нар бие

биеэ бас ингээд хараад байх боломж бол байгаа гэдгийг хэлье.

Кибер аюулгүй байдлын тухайд Монгол Улс бол 5 түвшний бэхжиж байгаа буюу голын түвшинд байна. Зохион байгуулалтын хувьд Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хамгаалах 3 төв ажиллаж байгаа. Энэ удаа Байнгын хороон дээр энэ асуудлыг ярина гэж ойлгож байгаа Золоо даргаа. Төрийн байгууллагуудын кибер аюулгүй байдлыг Тагнуулын ерөнхий газрын дэргэд байдаг Үндэсний суурьт буюу Кибер аюулгүй байдлын үндэсний төв хангаж байгаа. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд кибер халдлага зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтийн төв бол манай яамны дэргэд байдаг. Батлан хамгаалах салбарын Кибер аюулгүй байдлын төв гэсэн 3 байгууллага ажиллаж байгаа.

Монгол Улс бол кибер аюулгүй байдалтай холбоотой хууль, эрх зүйн орчноо баталсан. Парламентын гишүүддээ баярлалаа. 20 оноо авахаас 19 оноотой байгаа. Техник, технологийн хувьд сайжруулах ийм шаардлага байгаа. Энэ дээрээ 6.7 оноотой байгаа. Өнөөдөр Монгол Улсын төрийн байгууллага, агентлагууд бүгдээрээ софтвер/software/ хөгжүүлдэг, хаанаа цоорхой байгаа вэ гэдгээ хангалттай мэдээлэл байдаггүй. Мэдээлэл алдагдах эрсдэл зарим байгууллага дээр байдаг учраас нийтийн төв, тагнуулын байгууллага энийг нь тодорхойлж өгдөг.

Тэгэхээр яамны зүгээс хийгдэх нэг том ажил бол Монгол Улсын кибер аюулгүй байдлын зэрэглэл ямар түвшинд байгаа юм бэ? Аль салбар дээрээ бид нар мэдээллийг алдах эрсдэлтэй вэ гэдгээ 2025 онд тодорхойлно.

Гадаад хамтын ажиллагааг сайжруулах шаардлага байгаа. Ер нь ингээд бүх салбар ингээд дэлхийн мэргэжлийн холбоондоо элсээд ингээд явдаг гэдгийг бүгдээрээ мэднэ. Ай Ти Ю/ITU/ гээд харилцаа холбооны байгууллага гэдэг шиг. Тэгэхээр бид нар

энэ жилээс эхлүүлээд кибер аюулгүй байдлын чиглэлээр гадаад хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай гэдэг оноо гарч байгаа.

Чадавх бэхжүүлэх ажил дээр Их Хурлын гишүүд дэмжиж өгөөрэй. Цоо шинэ салбар учраас яг мэргэжлийн боловсон хүчний шаардлага, хэрэгцээ маш их байгаа. Тийм учраас энэ чиглэлээр ажилладаг томоохон их сургуулиудтай хамтраад.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Пунсалмаа гишүүн хариултаа авсан уу? Тэгвэл би асуултаа асууя.

Интернэтийн аюулгүй байдлыг хиймэл дагуултай болсноороо сайжруулна гэж байгаа. Тэгээд газрын эх үүсвэр нь эндээ байх дээр 4 антен, Францад 1 байх юм байна, Японд 1 байх юм байна гэж ойлгосон, б. Тэгээд дотоодын тэр 4 антены маань интернэтийн эх үүсвэр нь ялгаагүй нөгөө хойноос, урдаас орж ирж байгаа шилэн кабель байж таарах байх. Тэгэхээр өөрөөр хэлбэл ямар нэгэн байдлаар урд, хойд талын шилэн кабель дээр асуудал гарахад ялгаагүй л интернэтийн эх үүсвэр байхгүй болох юм биш үү гэдэг нэг асуулт. Интернэтийн аюулгүй байдлыг яаж нэмэгдүүлж байгаа юм болоо?

Хоёрдугаарт нь 36 км-ийн зайд байгаа энэ 1000 км-ийн зайд байгаа холын интернэтийн дамжуулах хурд нь хэр байх вэ? Ингээд орон даяар хэрэглэх гээд байна шүү дээ. Тэгээд ахуйн хэрэглээний тэр хурд литинз юм нь ямар байх вэ? Хангалттай байж чадах уу гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаарт нь монголчууд ямар байдлаар энэ төсөлд оролцох вэ? Бид нар нөгөө машин захиалчаад худалдаж аваад дараа нь унаад явах байх. Машины үйлдвэрлэлд манайх оролцох юм уу? Яг очиж танилцах биш хөгжүүлэлтэд нь оролцох уу гэж тийм асуулт байна.

5 номер.

**Ч.Золбаяр:** Золбаяр байна. Асуултад хариулъя. Интернэтийн эх үүсвэрийн тухайд бол нэгдүгээрт энэ Японд бол байхгүй энэ сайд өөрөө хэлчихнэ лээ. Ер нь бол Францын мэдлийн 2 арлын аль нэгэн рүү бид нар нөөц холболт гэтвей/geteway/ үүсэх ийм бололцоотой шийдэл танилцуулчихсан байгаа. Энэ шийдлийг бид нар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр танилцуулагдаад шийднэ.

Энэ нь ямар ач холбогдолтой вэ гэхлээр урд, хойд хөршөөс ямар нэгэн байдлаар 2 зэрэг манай интернэт байгалийн гамшиг гэдэг юм уу ямар нэгэн нөлөөгөөр интернэтийн холболт байхгүй болсон тохиолдолд бид нар тэр гарцаараа дамжуулаад интернэтийн олон улсын транкин/tranking/-гээ хийгээд транкин/tranking/ буюу олон улсын интернэтийн сүлжээнд холбоотой хэвээрээ байна гэсэн үг. Нэгдүгээр асуудал нь.

Хоёрдугаарх нь энэний аюулгүй байдал, найдвартай байдлын талаасаа Монгол Улсад шилэн кабелийн сүлжээ тасарсан гамшигт нөхцөл байдал үүссэн ийм тохиолдолд сансрын холбоогоороо бид нар энэ шилэн кабелийн тасарсан байгаа байгууллагуудаа, нэгжүүдээ харилцаа холбооны сүлжээтэйгээр байлгана гэсэн үг.

Ялангуяа онцгой байдал дээр бол нэн чухал ач холбогдолтой. Ямар нэгэн гамшиг, осол тохиолдсон үед хамгийн ойрхноор яривал газар хөдлөлт тохиолдсон үед хамгийн түрүүн шуурхай холбоо зохион байгуулж бид нар хохирлоос урьдчилан сэргийлдэг гэдэг ийм тооцооллыг бол энүүгээр гаргасан байдаг.

Интернэтийн дэлэй/delay/-ний асуудлыг ярьж байна. Мэдээж 36 мянган км-т дээр байгаа учраас 550км-т байж байгаа Старлинк/Starlink/-ийн дагуулаас хугацааны хоцрогдлын мил секундийн

хувьд бол харьцангуй ялгаатай гарна. Гэхдээ энэ хиймэл дагуул нь харилцаа холбооны хиймэл дагуул байгаа учраас энийг учиргүй шууд нөгөө рийл тайм /real time/ роботыг алсын зайнаас удирдана гэдэг юм уу ийм үйл ажиллагаанд ашиггүй, зөвхөн иргэдийн нийтлэг публик/public/ хэрэгцээнд зориулагдсан байдлаар ашиглах учраас энэ маань ер нь шууд хүнд бол мэдрэгдэхгүй.

Энийгээ ямар байдлаар шийдэгдэх вэ гэхээр энэ хурдны хоцрогдлыг бид нар зурвасынхаа өргөнийг нэмэх байдлаар нөгөө балансыг нь тохируулаад энэ байдал бол шийдэгдээд явдаг. Одоо ч гэсэн энэ зарчмаар бол хиймэл дагуулын холбоо фесат-ын сүлжээнүүд ажиллаад явж байгаа.

Монголчуудын оролцооны хувьд ярихад бол энэ хиймэл дагуулын сүлжээг бол бид нар “Мэдээлэл холбооны сүлжээ” компани дээр ажиллуулах гэж байгаа нь шилэн кабелийн үндсэн сүлжээг хариуцаж байгаа компани нь агаар, сансар гэсэн ийм хайбрид/hybrid/ маягийн ийм найдвартай сүлжээтэй болоод болчихно. Энэний цаана одоогийн үйлчилгээ явуулж байгаа компаниуд буюу шинээр бий болох “Ай Эс Пи” компаниуд бас энэ энэ өрхийн интернэтийн үйлчилгээг малчин иргэдэд, бусад үйлчилгээнд үйлчлэх энэ бололцоонууд нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан зарчмынхаа дагуу үйлчилгээ үзүүлэгч компаниуд нь энэ үндсэн сүлжээгээ аваад хэрэглэгчээ өөрөө бий болгоод ингээд бизнесээ эрхлээд явах ийм боломжийг нь бүрдүүлж байгаа, орчныг бий болгож байгаа гэсэн үг.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Гишүүдэд асуулт асууж дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү. Нэрээ өгөөрэй.

Анар гишүүн, Галбадрах гишүүн, Золжаргал.

Анар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

**Ч.Анар:** Үндэсний аюулгүй байдлын гадаад нөхцөл байдал хэцүүдсэн байгаа үедээ энэ нь бол өөрөө бодлогын хэмжээнд маш зөв юм. Энэ цаг үе нь ч зөв. Тэн дээр 100 хувь санал нийлж байгаа. Ач холбогдолтой.

Нөгөө талаасаа энэ үнэхээр тэр Золбаяр даргын ярьж байгаа шиг интернэт тасрах юм бол төрийн байгууллага болон тусгай чиг үүргийн байгууллагууд харилцаа холбооны хамгийн найдвартай хэрэгсэл бол үндэсний хиймэл дагуул гарцаагүй мөн. Украины дайн дээр ч гэсэн Старлинк/Starlink/-ийг хаасан эрсдэл үүсэж байсан. Тэгэхээр энэ дээрээс хамгаалах гарц гаргалгаа өнөөгийн нөхцөл байдал зөв байгаа. Нөгөө талаасаа технологийн хувиасаа сансар дахь байриллаа хадгалж үлдэх, давтамжаа авч үлдэх бас стратегийн ач холбогдолтой. Тэн дээр бол ямар ч маргаан байхгүй. Гол нь яг энэ зорилгоор хийхэд өртөг өндөр байна л гэдэг шүүмжлэлийг яриад байгаа юм. Ерөөсөө өртөг өндөр байна.

Хоёрдугаарт төр засгийн тэргүүнүүдэд, сайд нарт маань манай салбарынхан маань зөв мэдээллээ өгөөч. Тэгээд Золбаяр дарга өөрөө мэдэж байна шүү дээ. Та бид хоёр өөрөө 2001 онд орон нутгийг бас л хиймэл дагуулаар холбоод л явж байсан хүмүүс. Тэгээд 260 мянган малчдыг шууд бэлчээр дээрээсээ ярьдаг болгоно гээд байна. Тэгээд энэ чинь өртөгтэй, өрсөлдөж чадахгүй нам орбиттой. Цаг агаарыг тодорхойлдог болно, гамшигт болдог болно 5 Жи/5G/, Ай Ти/IT// гээд энэ нь өөрөө Засгийн газрын амлалт болоод байна. Баатархүү сайд энэ таны амлалт болоод дуусна шүү. Энэ нь биелбэл мэдээж гайхамшигтай. Гэхдээ энийгээ зөв мэдээллээ мэргэжлийнхэн маань сайд нартаа хангаж өгөөч. Энэ дээр л би санаа зовоод байгаа юм. Зөв мэдээллийг хүргэмээр байгаа юм.

Хоёрдугаарт сая дараагийн зүйл бол улсын нууцад хамаатай гэж мэдээлэл өгөхгүй байсан. Одоо улсын нууцад хамаагүй юм байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ чиглэлээрээ салбарынхаа экспертүүдийг тусгай чиг үүргийн байгууллагуудаа энэ ажлын багтаа оруулаач. Тагнуулын ерөнхий газраасаа оруулаач, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс экспертүүдээ оруулаад салбарын экспертүүдээ оруулахыг хүсье. Хамтарч ажиллаад. Бид нар идэх гэж байгаа талхаа ядаж амталж үзээд идэж асуудлыг нь дүгнэж мэднэ шүү дээ. Бид нар энэ өнгөрсөн хугацаанд хиймэл дагуулын үйлчилгээг маш сайн авч ашиглаж ирсэн улс. Тэгэхээрээ тэрийгээ бол Мобиком, ДДИШ, Монголсат, тэгээд энэ Нар станцын инженер, тэр инженерүүдээ ажлын хэсэгтээ оруулахыг хүсье.

Нөгөө талаасаа сая ярьж байгаа нь аюулгүй байдал чухал ч гэсэн энэ өөрөө хиймэл дагуул маань үнэхээр бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нууцлал стандартыг үйлдвэрлэхдээ хангаж байна уу гэдгийг шалгах ёстой.

Нөгөө тал дээр нь бас нэг юм байгаа Талес супер гэж яриад байгаа тэр 5 тэрбум Еврогоор хийж байгаа төсөл чинь дэлхийг бүрхэж байгаа төсөл. Дээрээс нь Талес супер юм бол яагаад Старлинк/Starlink/, Вань веб...гарч ирсэн юм бэ? Тэгэхээр Талес бол үйлдвэрлэгч Францын Засгийн газар маш ухаантай бидэнд технологио зарж байна. Би энд хоцрогдсон технологи гэж дурдаагүй Золбаяр даргаа уламжлалт гэж байгаа. Хиймэл дагуулын хөгжил 3 үетэй болчихсон байгаа. Уламжлалт, жижиг буюу орчин үеийн, Нео гээд. Тэгэхээр бид нар заавал энийг сонгох хэрэг байгаа юу л гэдэг асуудлыг яриад байгаа юм.

Тэгээд үндэсний хиймэл дагуултай ямар ч аргаар хамаа байхгүй ингээд шүүмжлэлтэй хэлэлцээд гарах гэж байгаа нь бол би инженер хүнийхээ хувьд бол баяртай байгаа. Гэхдээ яг энэ аргаар

уу гэдэг дээр нэлээн шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Галбадрах гишүүний микрофоныг нээж өгнө үү.

**Ж.Галбадрах:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ хиймэл дагуултай болох асуудлыг бол Цахим бодлогын хорооны гишүүний хувьд дэмжиж байгаа. Энэ бол үндэсний аюулгүй байдлын бодлоготой маш зөв, маш сайхан зохицож байгаа. Тэгэхээр энийг цаг хугацаа нь болжээ гээд манайх оруулж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ цаг хугацаагаа бас ийм том мега төсөл дээр ашиглах нь зөв гэж бодож байна. Би асуулт асууж чадсангүй. Яагаад гэвэл мэдээлэл их ховор байлаа. Энэ хаалттай хуралдана, ингэнэ тэгээд мэдээлэл нь Анар гишүүнээс асуухад мэдээлэл би аваагүй байна гэж байсан. Тэгэхээр бид нарын хувьд бас мэдээлэл дутуу байлаа. Жишээлбэл, энэ ТЭЗҮ нь харчихмаар байлаа. Тэгээд ТЭЗҮ дээр нь бас нэг бодоод өөрөө сая хэллээ интернэтээр ингээд бид нар олоод авчхаж болно шүү, ямар компанид, ямар үнэ өртгөөр хийдэг юм бэ гэвэл тэрийг бас нэг харьцуулчих ийм боломж байлаа. Тэгэхээр их мэдээлэл дутуу орж ирлээ гэдгийг нэгдүгээрт хэлчихье.

Тэгээд зөвхөн 1 компани биш өөр өөр компаниудын харьцуулалтыг бас хийх ийм боломж бид нарт бас байжээ. Тэгэхээр тийм юугүй учраас энэ дээр яг нэг шийдэл гаргаад ингээд хэлчих тийм тодорхой санал байсангүй.

Нөгөө талаас 2 төрлийн энэ хиймэл дагуул намын, өндрийн гээд яриад байна. Тэгээд яг батлан хамгаалах зорилгоор, улс орны үндэсний аюулгүй байдалдаа зориулсан өндөр дээрээ бас арай бага хэмжээнийхийг тавиад тэрийгээ харж, хийж болдог. Бас нам дээр нь энэ яг энэ интернэтийн энэ хямд өртөгтэй гэж яриад байгаа энэ технологио ашиглаад ийм хосолсон

байдал гэж бас байж болохгүй байсан юм болов уу гэсэн ийм бодлоо бас энэ дээр хэлчихье.

Хамгийн гол нь бас үг хэлье гэж байгаад энэ ойлголтоо нэгтгэх. Бид нар энэ салбар дотроо ойлголт нэгдэж байж бид нар Их Хурал дээр ойлголт нэгтэй болно гэж ингэж ярьж байгааг маш зөв гэж бодож байна. Тийм учраас салбар дотроо яг энэ чиглэлээр ажилладаг энэ хүмүүсийг бид нар нэгтгээд, нэлээн тийм нээлттэй хэлэлцүүлэг, уулзалтуудыг хийгээд, саналыг нь аваад ингээд яваач гэдгийг хэлэх гэж байна.

Дараа нь түрүүн Золжаргал даргын асуулт байсан тэрийг би бас яг хэлье гэж бодож байна. Тэгээд үйлдвэрлэх явцад нь монголчуудыг оруулж тэн дээр сурч авах, тэр үйлдвэрлэл ингээд яг энэ хиймэл дагуулын мэргэжилтнүүдийг бид нар энэ дээрээ бас ингэж бэлдэж авна. 27 онд бид нар бол хөөргөнө гэж байна. Тэгээд энэ хүртэл хугацаанд бүүр зориулалтаар тэр үйлдвэрлэлийнх нь явцад нь оруулаад явах нь зүйтэй. Тэгээд ашиглалт гэж гарч ирнэ. Ялт ч үгүй энэ.

Тэгэхээр энэ ашиглалтыг бид нар өөрсдөө үйлдвэрлээгүй учраас Францын тэнд л асуудлуудыг шийднэ гэх биш, яг үндэсний инженерүүдээ бэлдэж авах нь зүйтэй юм гэдэг санал үгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Та бүхэндээ мэдээлэл өгсөн, асуултад хариулсанд баярлалаа. Би бас нэг бодлоо хуваалцъя гэж бодож байна.

Мэдээж цаг үеэ дагаад үндэсний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалд өөрийн гэсэн эх үүсвэртэй, үгүй ядаж олон төрөлт эх үүсвэртэй интернэтийн харилцаа холбоо байх нь чухал гэдэг дээр бүгд санал нийлж байгаа. Энэ төсөл өөрөө том төсөл, 212 сая Евро, 700 тэрбум төгрөг гэдэг бол бас бага мөнгө биш. Тэрний цаана сонгосон хувилбар яг зөв юм уу гэдэг

эргэлзээ энэ зарим хүмүүс, салбарын хүмүүст нь байна.

Тийм болохоор мэдээлэл маань өөрөө тийм нууцын ангилалд ороогүй юм байна. Тийм болохоор энийг ТЭЗҮ-ийн тоонуудыг, эдийн засгийн тооцоонуудыг нь ийм Байнгын хорооны хурал дээр биш ажлын шугамаар та бүхнийг урьж мэдээлэл авч нэлээн сайн дэлгэрэнгүй ярилцъя гэж бодож байна. Асуулт, хариулт, бид нарын энэ хэлэлцээж байгаа зүйл нь улс төрийн өнцөгтөө, эсвэл энэ төслийг ер нь дэмжих нь дэмжчих юм бол малчин болгон утсаараа яриад, интернэтээ ингээд хэрэглэдэг ийм ирээдүй хүлээж байна гэж ер нь бүх шатандаа ярьж байгаа. Ингэхийн оронд зорилго нь юу юм, техникийн чадамж нь юу юм, хэдэн төгрөг болох юм, ирэх 10 жил төсвөөс гаргах мөнгө, дараа нь татаас нь дахиад ингээд хэдэн жил ажиллахад хэдэн төгрөг гарах юм? Иймэрхүү техникийн, эдийн засгийн,

Гуравт нь бодлогын, аюулгүй байдлын шалгууруудыг тодорхой тавиад тэрэндээ ярилцах юм бол энэ гишүүдийн ойлголт ч сайжирна, энэ төсөл ч өөрөө илүү бодитой, хүмүүсийн гарах хүлээлт ч гэсэн бодитой байх болов уу гэж бодож байна. Ингээд та бүхэндээ цаг гаргаж өргөн мэдээлэл өгсөнд баярлалаа. 4 номерын микрофон нээж өгнө үү.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ бас талархаж байна. Анар гишүүний саналуудыг би бас хүндэтгээж хүлээж авч байна.

Тэгэхээр мэдээж үндэсний хиймэл дагуултай болох нь цаг үеийн хувьд бол зөв гэдгийг би бас мэргэжлийн хүний хувиар хэлж байна гэж ойлгож байна. Тэгэхээр цаашидаа алдаа гаргахгүйн тулд энэ ТЭЗҮ дээрээ, одоо энэ гэрээн дээрээ бас бодитой саналуудаа тусгаад явах нь зөв гэж би хэлж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр зарчмын хувьд хиймэл дагуултай болохыг мэдээж гишүүд

маань бас дэмжиж байна. Гол нь энэ мэргэжлийн экспертүүдийн саналуудыг тусгах дээр бол дутагдалтай байна гэж байгаа юм. Тэгээд яах вэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд нэлээдгүй л бас ажлууд өрнөсөн л дөө. Тэгээд би бас Анар гишүүнтэй ч гэсэн энэ Талесыг сонгох асуудлаар бас ярилцаж одоо Америкийн тэр НАСА дээр хүртэл хамт очиж, бид нар ярилцаж байсан. Тэгээд яах вэ зам нь зөв ч гэсэн алдаа гарчих вий гэдэг болгоомжлол бол байгааг би бас хүлээж авч байна.

Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчийн хувиар Баатархүү сайдад бол бид нар бас цаашидаа энэ экспертүүдийгээ нэг уриад, дэд ажлын хэсгээ ахиж байгуулаад, эцсийн байдлаар нэг танилцуулгуудаа хийгээд, Байнгын хорооны гишүүддээ тухайлан тэр ТЭЗҮ, тооцоо, үндэслэл юмнуудыг нь үзүүлээд, одоо бол Францын инженерүүд ирчихсэн байгаа шүү дээ. Жишээ нь, энэ үеэр нь энэ Анар гишүүнтэй, энэ мэргэжлийн хүмүүстэй тэр Францын инженерүүдийг бас нэг уулзуулмаар байгаа юм. Тэрийг Баатархүү сайд зохион байгуулах хэрэгтэй. Мэргэжлийн яам нь байна, энэ яамыг удирдаж байгаа, энэ салбарыг удирдаж байгаа сайд нь байгаа. Тийм учраас Баатархүү сайд энэ уулзалтуудаа зохион байгуулаад, экспертүүдийнхээ саналуудыг тусгаад тэгээд ингээд явах нь бол зөв.

Хоёрт, түрүүн надаас асуусан тэр цэрэгжилттэй ч юм уу холбоотойгоор янз бүрийн нууц сүлжээ байгаа юм биш биз дээ гээд. Тийм зүйл байхгүй. Түүнийг тэгж нууцлаад байгаа юм бол байхгүй гэдгийг бас хариуцлагатай хэлсэн. Тэрнээс биш энэ өөрөө Аюулгүйн зөвлөл дээр нөгөө нууц гэж танилцуулж явж байгаа яг тэр ТЭЗҮ болон техникийн асуудлуудыг. Энийг шууд ил цагаан батлагдаагүй байхад нь шууд дэлгэж ярих бас тийм зохимжгүй. Нөгөө талаас ч тэр, манай талаас ч тэр энэ бол үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг утгаараа Аюулгүйн зөвлөл дээр танилцуулахдаа

хүртэл нууцаар танилцуулаад явж байгаа.

Гэхдээ бид бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар чиглэл авна. Тэрнээс биш эцсийн дүгнэлт биш. Чиглэл авсны дараа бид нар тодорхой мэдээллүүд тэр ТЭЗҮ юмнуудыг бол Байнгын хорооны даргад, гишүүдэд, зарим тэр техник, ТЭЗҮ-гийн үндэслэл энэ тэрийг нууц гээд тамга дараад бас явуулах бололцоотой шүү дээ.

Тэгэхээр та бүхэн бол мэдээж тэр нууц гэсэн бичигтэйгээ танилцаад, тэгээд хаа хаанаа хэн хэн нь хариуцлагатайгаар асуудалдаа хандаад л явчихад бол болохгүй зүйл бол байхгүй гэж ингэж бодож байна. Тэгэхээр Баатархүү сайд Засгийн газрын зүгээс.../минут дуусав./

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Ерөнхийдөө үндэсний аюулгүй байдал гэдэг үгийн доор ингээд юм нуугаад тэгээд дараа нь хэл ам гардаг нэг тийм хандлага байдаг шүү дээ. Тэр тал дээрээ та бүхэн боломжтой мэдээллээ хуваалцаад ажиллахдаа анхаарна биз дээ гэж бодож байна.

Ингээд гишүүд үг хэлж дууссан. “Үндэсний хиймэл дагуул төсөл”-ийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мэдээллийг сонслоо.

Та бүхнийг цаг гаргаж ирсэнд баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал ирсэн хүсэлтийн дагуу хаалттай хэлэлцэгдэнэ. Хурлаа хаая.

17.00 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР



